



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2022/23/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:  
reakomaudit@gmail.com  
Дархан-Уул аймаг  
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**  
Утас: **7037-3089**  
Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)  
Ахлах аудитор: **С.Батцэцэг**  
Утас: **7037-3089**  
Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)  
Аудитор: **А. Батболд**  
Утас: **9906-9301**  
Цахим хаяг: [ayushbatbold4@gmail.com](mailto:ayushbatbold4@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-р баг  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН 18  
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.ДЭЖИДМАА ТАНАА

2022.02.25 № 166

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/Ш.МӨНХБАЯР

009020781

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>57,670,607.00</b>	<b>49,597,191.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>57,670,607.00</b>	<b>49,597,191.00</b>
<b>35,100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>21,204,978.00</b>	<b>15,703,052.00</b>
35,110	Тусгай зориулалттай материал	18,702,521.00	13,303,620.00
35,130	Эм боох материал	2,502,457.00	2,399,432.00
<b>35,400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>36,465,629.00</b>	<b>33,894,139.00</b>
35,410	Бичиг хэргийн материал	2,011,150.00	1,529,150.00
35,420	Аж ахуйн материал	4,720,120.00	3,139,260.00
35,430	Сэлбэг хэрэгсэл	1,433,100.00	2,133,100.00
35,450	Барилгын засварын материал	165,000.00	165,000.00
35,460	Хүнсний материал	1,420,410.00	2,048,080.00
35,470	Бусад хангамжийн материал	26,715,849.00	24,879,549.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,659,855,523.88</b>	<b>1,611,736,253.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,659,855,523.88</b>	<b>1,611,736,253.12</b>
<b>39,200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,214,043,467.20</b>	<b>1,166,111,579.80</b>
39,201	Барилга, байгууламж, орон сууц	1,194,089,956.00	1,194,089,956.00
39,202	Хуримтлагдсан элэгдэл	(43,448,299.17)	(83,813,968.41)
39,205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	44,501,918.00	42,762,868.00
39,206	Хуримтлагдсан элэгдэл	(31,429,821.09)	(32,028,870.89)
39,207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,601,606.00	66,469,626.00
39,208	Хуримтлагдсан элэгдэл	(26,530,610.65)	(32,087,654.69)
39,214	Бусад үндсэн хөрөнгө	16,133,425.00	16,133,425.00
39,215	Хуримтлагдсан элэгдэл	(3,874,706.89)	(5,413,801.21)
<b>39,300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>445,812,056.68</b>	<b>445,624,673.32</b>
39,301	Програм хангамж	1,324,300.00	1,124,300.00
39,302	Хуримтлагдсан элэгдэл	(612,243.32)	(599,626.68)
39,303	Бусад биет бус хөрөнгө	445,100,000.00	445,100,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,717,526,130.88</b>	<b>1,661,333,444.12</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,717,526,130.88</b>	<b>1,661,333,444.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,717,526,130.88</b>	<b>1,661,333,444.12</b>
51,100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	722,511,532.00	722,511,532.00
<b>51,200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(208,369,973.14)</b>	<b>(264,562,659.90)</b>
51,210	Өмнөх үеийн үр дүн	(179,507,713.41)	(208,369,973.14)
51,220	Тайлант үеийн үр дүн	(28,862,259.73)	(56,192,686.76)
51,300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,203,384,572.02	1,203,384,572.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,717,526,130.88</b>	<b>1,661,333,444.12</b>

Пийк-Ом Аудит ХХК

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>614,430,300.00</b>	<b>604,783,442.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,662,100.00</b>	<b>4,535,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>19,662,100.00</b>	<b>4,535,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>175,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,662,100.00	4,360,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>594,768,200.00</b>	<b>600,248,442.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>564,288,800.00</b>	<b>559,032,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	564,288,800.00	559,032,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>245,000.00</b>	<b>183,142.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	183,142.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	245,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,234,400.00</b>	<b>41,032,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,234,400.00	41,032,500.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>643,292,559.73</b>	<b>660,976,128.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>643,292,559.73</b>	<b>660,976,128.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>611,973,493.73</b>	<b>645,857,609.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>434,244,794.00</b>	<b>450,200,800.87</b>
210101	Үндсэн цалин	340,718,010.00	326,713,386.87
210102	Нэмэгдэл	68,402,790.00	98,232,686.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	579,000.00	705,000.00
210104	Урамшуулал	24,544,994.00	24,549,728.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,280,600.00</b>	<b>58,453,594.85</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,129,055.22	38,361,337.93
210202	Тэтгэмжийн даатгал	7,219,101.53	6,142,897.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,513,292.44	2,897,206.07
210204	Ажилгүйдлийн даатгал	378,327.09	1,704,376.20
210205	Эрүүл мэндийн даатгал	8,040,823.72	9,347,776.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,562,320.00</b>	<b>30,900,189.70</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,600,013.00	5,117,365.80

Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	14,803,460.00	15,481,513.90
210303	Цэвэр, бохир ус	8,158,847.00	10,301,310.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,610,250.00</b>	<b>11,829,961.00</b>
210401	Бичиг хэрэг	834,500.00	526,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	414,200.00
210404	Ном, хэвлэл	20,500.00	42,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,755,100.00	389,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,150.00	1,873,200.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	8,584,261.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,634,903.00</b>	<b>29,975,292.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	991,603.00	650,567.00
210502	Хоол, хүнс	34,643,300.00	29,160,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	164,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,666,500.00</b>	<b>8,453,700.00</b>
210604	Урсгал засвар	1,666,500.00	8,453,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>525,000.00</b>	<b>1,206,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	525,000.00	350,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	416,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,449,126.73</b>	<b>54,837,470.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	448,970.00	170,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	524,000.00	692,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,476,156.73	53,974,270.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,319,066.00</b>	<b>15,118,519.58</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>172,080.00</b>	<b>6,999,810.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,080.00	6,999,810.30
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>31,146,986.00</b>	<b>8,118,709.28</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,146,986.00	8,118,709.28
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(28,862,259.73)</b>	<b>(56,192,686.76)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(28,862,259.73)</b>	<b>(56,192,686.76)</b>

Пийк-Ом Аудит ХХК

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	-179,507,713.41	1,746,388,390.61
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	-179,507,713.41	1,746,388,390.61
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-28,862,259.73	-28,862,259.73
10	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	-208,369,973.14	1,717,526,130.88
11	2021 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	-208,369,973.14	1,717,526,130.88
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	-208,369,973.14	1,717,526,130.88
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-56,192,686.76	-56,192,686.76
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	-264,562,659.90	1,661,333,444.12

Пийк-Ом Аудит ХХК

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>594,523,200.00</b>	<b>600,423,442.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>175,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>175,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>175,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	175,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>594,523,200.00</b>	<b>600,248,442.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>564,288,800.00</b>	<b>559,032,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	564,288,800.00	559,032,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>183,142.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	183,142.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,234,400.00</b>	<b>41,032,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,234,400.00	41,032,500.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>593,644,200.00</b>	<b>598,928,442.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>593,644,200.00</b>	<b>598,928,442.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>562,325,134.00</b>	<b>583,809,922.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>434,244,794.00</b>	<b>450,200,800.87</b>
210101	Үндсэн цалин	340,718,010.00	326,855,972.12
210102	Нэмэгдэл	68,402,790.00	98,095,476.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	579,000.00	705,000.00
210104	Урамшуулал	24,544,994.00	24,544,352.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,280,600.00</b>	<b>58,453,594.85</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,123,649.57	38,361,337.93
210202	Тэтгэмжийн даатгал	12,224,511.18	6,142,897.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,513,292.44	2,897,206.07
210204	Ажилгүйдлийн даатгал	378,323.09	1,704,376.20
210205	Эрүүл мэндийн даатгал	8,040,823.72	9,347,776.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,562,320.00</b>	<b>30,900,189.70</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,600,013.00	5,117,365.80
210302	Түлш, халаалт	14,803,460.00	15,481,513.90
210303	Цэвэр, бохир ус	8,158,847.00	10,301,310.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,905,300.00</b>	<b>2,706,042.00</b>
210401	Бичиг хэрэг	240,000.00	540,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	87,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,356,700.00	534,542.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,708,600.00	1,043,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,257,150.00</b>	<b>30,328,095.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,635,900.00	375,700.00
210502	Хоол, хүнс	32,621,250.00	29,788,395.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	164,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>8,728,500.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	8,728,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>675,000.00</b>	<b>1,022,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	675,000.00	175,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	407,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,899,970.00</b>	<b>1,470,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	999,970.00	170,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	1,300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,319,066.00</b>	<b>15,118,519.58</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>172,080.00</b>	<b>6,999,810.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,080.00	6,999,810.30
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>31,146,986.00</b>	<b>8,118,709.28</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,146,986.00	8,118,709.28
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>879,000.00</b>	<b>1,495,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>879,000.00</b>	<b>1,495,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>879,000.00</b>	<b>1,495,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>879,000.00</b>	<b>1,495,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	879,000.00	1,495,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(879,000.00)</b>	<b>(1,495,000.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>24</b>	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>605,661,300.00</b>	<b>584,946,780.42</b>	<b>-20,714,519.58</b>	<b>96.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>605,661,300.00</b>	<b>584,946,780.42</b>	<b>-20,714,519.58</b>	<b>96.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>605,661,300.00</b>	<b>584,946,780.42</b>	<b>-20,714,519.58</b>	<b>96.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>451,081,600.00</b>	<b>450,200,800.87</b>	<b>-880,799.13</b>	<b>99.80</b>
210101	Үндсэн цалин	370,365,900.00	326,855,972.12	-43,509,927.88	88.25
210102	Нэмэгдэл	52,989,400.00	98,095,476.00	45,106,076.00	185.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,181,300.00	705,000.00	-2,476,300.00	22.16
210104	Урамшуулал	24,545,000.00	24,544,352.75	-647.25	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,535,000.00</b>	<b>58,453,594.85</b>	<b>-3,081,405.15</b>	<b>94.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	43,491,800.00	38,361,337.93	-5,130,462.07	88.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,510,800.00	6,142,897.84	1,632,097.84	136.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,608,700.00	2,897,206.07	-711,493.93	80.28
210204	Ажилгүйдлийн даатгал	902,100.00	1,704,376.20	802,276.20	188.93
210205	Эрүүл мэндийн даатгал	9,021,600.00	9,347,776.81	326,176.81	103.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,900,000.00</b>	<b>30,900,189.70</b>	<b>-6,999,810.30</b>	<b>81.53</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,247,100.00	5,117,365.80	-2,129,734.20	70.61
210302	Түлш, халаалт	18,104,600.00	15,481,513.90	-2,623,086.10	85.51
210303	Цэвэр, бохир ус	12,548,300.00	10,301,310.00	-2,246,990.00	82.09
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,522,900.00</b>	<b>2,522,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	540,000.00	540,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	500,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	87,900.00	87,900.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	351,400.00	351,400.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,043,600.00	1,043,600.00	0.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,795,600.00</b>	<b>31,043,095.00</b>	<b>-9,752,505.00</b>	<b>76.09</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	375,700.00	375,700.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	39,540,900.00	29,788,395.00	-9,752,505.00	75.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	879,000.00	879,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,508,500.00</b>	<b>9,508,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	780,000.00	780,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	8,728,500.00	8,728,500.00	0.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>847,000.00</b>	<b>847,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	440,000.00	440,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	407,000.00	407,000.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,470,700.00</b>	<b>1,470,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,700.00	170,700.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>605,661,300.00</b>	<b>584,946,780.42</b>	<b>-20,714,519.58</b>	<b>96.58</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>559,032,800.00</b>	<b>550,914,090.72</b>	<b>-8,118,709.28</b>	<b>98.55</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	559,032,800.00	550,914,090.72	-8,118,709.28	98.55
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>46,628,500.00</b>	<b>34,032,689.70</b>	<b>-12,595,810.30</b>	<b>72.99</b>
320001	Орон нутгийн төсвөөс	46,628,500.00	34,032,689.70	-12,595,810.30	72.99
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>39</b>	<b>39</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7	7	0.00	100.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>350</b>	<b>131.4</b>	<b>-218.60</b>	<b>37.54</b>
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>350</b>	<b>131.4</b>	<b>-218.60</b>	<b>37.54</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	350	131.4	-218.60	37.54
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39</b>	<b>39</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	27	27	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	1.00	100.00

*Пийк-Ом Аудит ХХК*

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>183,142.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	183,142.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	183,142.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	183,142.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>183,142.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	183,142.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	183,142.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд ур чадварын нэмэгдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Я. Батбаяр, аудитор Б. Оюунцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг Пийк-Ом Аудит ХХК-ны чанарын хяналтын менежер Б.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

18 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрийг өв тэгш хөгжүүлж, төлөвшүүлэхэд бүрэн дэмжлэг үзүүлэхүйц сургалтын орчин бүрдүүлж, өөрөө суралцах хөгжих чадавхитай монгол хүмүүнийг төлөвшүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Цэцэрлэгийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 643,292.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,432.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,824.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,294.2 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	57,670.6	49,597.2	(8,073.4)
Үндсэн хөрөнгө	1,659,855.5	1,611,736.2	(48,119.3)
Нийт хөрөнгө	1,717,526.1	1,661,333.4	(56,192.7)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,717,526.1	1,661,333.4	(56,192.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,717,526.1	1,661,333.4	(56,192.7)

Бараа материал дансны үлдэгдэл 8,073.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 42,370.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, эрхлэгчийн 2021 оны 5 дугаар сарын 28-ны А/17 дугаар “Хөрөнгө актлаж данснаас хасах тухай” тушаалаар 8,584.2 мянган төгрөгийн бараа материал актлаж, 41,859.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд төсвийн хөрөнгөөр 1,495.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, эрхлэгчийн 2021 оны 5 дугаар сарын 28-ны А/19 дүгээр “Хөрөнгө орлого авах тухай” тушаалаар 2.450.0 мянга, 2021 оны 12 сарын 20-ны А/30 дугаар тушаалаар 1,910.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил тус тус хандиваар авч, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны 01-А/398 тоот захирамжаар элэгдэлээрээ анхны өртөгөө нөхсөн нийт 9 нэр төрлийн хөрөнгө буюу 5,926.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил актлаж, 53,974.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 1,611,333.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,661,333.4 мянган төгрөг болж 56,192.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 9,646.9 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн орлого 15,302.1 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 17,683.6 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин урамшууллын зардал 15,956.0 мянга, хангамжийн материалын зардал 7,219.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 6,787.2 мянган төгрөгийн зардлууд байна. Энэ нь өмнөх оны төсөвт 3 орон тооны цалингийн зардал дутуу байсныг тайлант онд нэмж батлуулсан, эрхлэгчийн тушаалаар хангамжийн материал актлаж, барилгын гадны пасадны урсгал засвар хийсэнтэй тус тус холбоотой.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 705,220.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,303.7 мянган төгрөгөөр бууруулж, 639,916.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 456,668.4 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 35,823.1 мянга, тайлант оны батлагдсан төсвөөс 41,359.2 мянган төгрөгөөр, хоол хүнс норматив зардлыг 169,290.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 84,880.4 мянга, тайлант оны батлагдсан төсвөөс 50,787 мянган төгрөгөөр өндөр байгаа нь тайлант жилд нэг хүүхдэд ногдох норматив зардлын хүүхдийн тоог өндөр тооцоолон төсөвлөснөөс шалтгаалжээ.

Төсвийн тодотголоор 605,661.3 мянган төгрөг болгож 34,255.2 мянган төгрөгөөр бууруулсан нь Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 А/525 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын цахим болон танхимын сургалтанд шилжсэнтэй холбоотой юм.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 605,661.3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 559,032.8 мянга, орон нутгийн төсвөөс 46,628.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 559,032.8 мянга, орон нутгийн төсвөөс 41,032.5 мянга, нийт 600,065.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 584,946.8 мянган төгрөгийг зарцуулж, 15,118.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,946.8 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байна. 2021 онд тогтмол зардал 6,999.8 мянга, норматив зардал 9,752.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна. Энэ нь ковидын нөхцөл байдлын улмаас хөл хорио тогтоосноос тогтмол зардал болон хоолны зардал буурчээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 183.1 мянган төгрөг орж ирсэнээс 183.1 мянган төгрөгийг хог хаягдал зайлуулах, хортон шавьж устгахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохиох 151 мэдээллийг хугацаандаа бүрэн оруулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 3,238.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/34 тоот албан бичгээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 100 хувьтай байлаа.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,875.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 8,030.0 мянган төгрөгийн алдааг залруулан, 4,845.2 мянган төгрөгийн 1 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- Бараа материалыг дансны ангиллыг 7,928.5 мянган төгрөгөөр буруу бүртгэсныг
- 101.5 мянган төгрөгийн эмнэлэгийн багаж хэрэгслийг шууд зардалд тусгасныг тус тус залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Цалингийн зардлын данстай холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 25-ны Б/13 тоот тушаалаар 13 багш, ажилтан нарт ур чадварын нэмэгдлыг холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлэхгүйгээр 4,845.2 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3 “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр нийгмийн хамааллын сайд, сангийн сайдын хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 сарын 1-ны А/35, А/10, 9 дугаар тушаалын хавсралтын 5 “Энэ шалгуур үзүүлэлтийн 3-д заасан нийтлэг шалгуурыг хангасан цэцэрлэгийн багш ажилтаны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус үнэлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр нийгмийн хамааллын сайд, сангийн сайдын хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 сарын 1-ны А/35, А/10, 9 дугаар

тушаалын хавсралтын 5 “Энэ шалгуур үзүүлэлтийн 3-д заасан нийтлэг шалгуурыг хангасан цэцэрлэгийн багш ажилтаны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан-Уул аймгийн 18 дугаар цэцэрлэг	2	12,875.2	1	8,030.0	-	-	0	0	1	4,845.2
	Дүн	2	12,875.2	1	8,030.0	0	0	0	0	1	4,845.2

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.25